



ДОРНОД АЙМАГ  
ХЭРЛЭН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 01 сарын 21 одор

Дугаар 04/04

Чойбалсан

Сумын Засаг даргын 2025-2028 оны  
үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1, 35 дугаар зүйлийн 35.1.5, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

- Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
- Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулахыг сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч (С.Мөнхжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.ТАМИРЖАРГАЛ

2125010007

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2025 оны 02 дугаар сарын 21-  
ний өдрийн 07/07.. дугаар тогтоолын  
хавсралт

## ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2025-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал зэрэг баримт бичгүүдийг үндэслэл болгов.

Хөтөлбөрийг боловсруулахдаа нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангах, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хадгалж, засаглалыг сайжруулах, иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бурдуулэх, хариуцлагын тогтолцоог сайжруулах үүднээс ШИНЭ ЧОЙБАЛСАН ХОТ-ыг бий болгох хүрээнд Төсвийн ерөнхийлөн захирагчийн 5 бүлэг, 53 зорилтын хүрээнд 240 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгав.

### НЭГ . ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

#### 1.1. Боловсрол

Иргэн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломжийг бурдуулж, сургалтын чанар хүртээмжийг дээшлүүлэн, соёл уламжлал дээдэлсэн, хүмүүнлэг ёс зүйтэй иргэний төлөвшүүлнэ.

##### 1.1.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, коллежийн сурагчдын амжилтыг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1.1.1.1. Хүүхдийн хөгжлийн онцлог, суралцах чадамжид суурилсан уян хатан сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга замыг эрэлхийлнэ.

1.1.1.2. Аймаг, улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй олимпиадад оролцох оролцогчдыг дэмжиж, амжилтыг урамшуулан ажиллана.

1.1.1.3. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулж, туршлага солилцох ажлыг тогтмол зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллана.

##### 1.1.2. Боловсролын байгууллагын барилга, байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт чанарын шаардлага хангасан, тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бурдуулнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа :

1.1.2.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилгын их засварыг үе шаттайгаар хийх

1.1.2.2. Сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн хүртээмжийг нэмэгдүүлэх

1.1.2.3. Цэцэрлэг, сургууль болон спорт заалыг шинээр барих, өргөтгөх замаар хамрагдалтыг нэмэгдүүлэн, ачааллыг багасгах

1.1.2.4. Стандартад нийцсэн кабинет, цахим анги танхимиын тоог нэмэгдүүлнэ.

1.1.3. Боловсролын бүх шатанд хуухдийн хөгжил хамгааллын орчныг сайжруулах, хуухдийн сурч, хөгжих тэгш эрхийг хангах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1.1.3.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурх, хөгжих шаардлагатай хэрэглэгдэхүүнээр ханган багшлах боловсон хүчнийг нэмэгдүүлэн ажиллана.

1.1.3.2. Сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж чадахгүй байгаа ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдэд гэр бүл, амьдрах орчинд тулгуурлан зохих сургалтад хамруулах ажлыг зохион байгуулна.

1.1.3.3. Сургууль цэцэрлэгийн гол тогооны эрүүл ахуй, стандартыг хангуулж, эрүүл шим тэжээлтэй хоол хүнсээр хангах, хяналт, хариуцлагыг сайжруулна.

1.1.3.4. Суралцагчдын дунд үе тэнгийн дээрэлхэлт, цахим гэмт хэргээс хамгаалах, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

1.1.3.5. Дотуур байрны хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулан, “Дотуур байр бидний гэр” төслийг хэрэгжүүлнэ.

1.1.3.6. Алслагдсан сургуулиудад хүүхдийн автобусны тоог нэмэгдүүлнэ.

1.1.3.7. Сургуулийн орчин дахь гэрэлтүүлэг, гарц, гэрлэн дохио камер, хурд сааруулагчийг нэмэгдүүлж, хүүхдийн зам тээврийн осол, зөрчилд өргөхөөс сэргийлнэ.

1.1.4. Багш, удирдах ажилтны мэргэжил үр чадварыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1.1.4.1. Багш, дасгалжуулагч, удирдах ажилтны мэргэжил, арга зүйн тасралтгүй хөгжлийг дэмжих, гадаад болон дотоодод туршлага судлах, нийгмийн баталгааг хангах бодлогыг дэмжинэ.

1.1.4.2. Багшийн ёс зүйг эрхэмлэн сахих, багшийн үнэлээмжийг нэмэгдүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, багш эцэг эхчүүдийн хамтын харилцааг сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулна.

1.1.4.3. Ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйч, хоол зүйчийн орон тоог бүрэн орон тоогоор ажиллуулна.

1.1.4.4. Боловсролын байгууллагын өөрийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, дэмжин ажиллах, багш ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллана.

1.1.5. Иргэдийг насан туршдаа тасралтгүй суралцахыг дэмжин, сургалтын орчин нөхцөл бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1.1.5.1. Насан туршийн боловсролын үйл ажиллагааг хөгжүүлэх, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх

1.1.5.2. Өсвөр үеийнхэнд хувь хүний төлөвшил, үр чадвар, хүмүүжлийн боловсрол олгох арга зүйг түгээн дэлгэрүүлнэ.

1.1.5.3. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүл иргэдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.

### 1.2. Эрүүл мэнд

Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэдийг нэмэгдүүлэх

1.2.1. Эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжсэн нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1.2.1.1. Нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ үзүүлэх, чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, холбогдох санхүүжилтийг шийдвэрлэнэ.

1.2.1.2. Халдварт бус өвчинөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг салбар дундын оролцоотойгоор хувь хүн, гэр бүл, байгууллага, аж ахуйн нэгж, багийн хүрээнд хэрэгжүүлнэ.

1.2.1.3. Эрт илрүүлэг арга хэмжээний хүрээнд зорилтод бүлгийн хамрагдалт, урьдчилан сэргийлэлт, хяналт, эмчилгээг эрчимжүүлнэ.

1.2.1.4. Өвчлөл нас баралтад нөлөөлж буй хүчин зүйлсийн тархалтыг тогтоох судалгаанд тулгуурласан урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1.2.1.5. Чойбалсан хотын хэмжээнд осол гэмтлээс сэргийлэх хөтөлбөр гаргаж, нөлөөлөх үйл ажиллагааг зохион байгуулна.

1.2.2. Эрүүл мэндийн байгууллагуудын чадавхыг дээшлүүлж, иргэдийг орон нутагтаа нарийн мэргэшлийн тусlamж үйлчилгээг авах боломжийг нэмэгдүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1.2.2.1. Өрхийн эрүүл мэндийн эмчилгээний төвийн тоног төхөөрөмжөөр хангах тал дээр анхаарч үе шаттайгаар сайжруулна.

1.2.2.2. Оношилгоо, эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэд орон нутагтаа бүрэн оношлогдох, эмчлэгдэх боломжийг бүрдүүлнэ.

1.2.2.3. Нарийн мэргэжлийн эмч, анхан шатны эрүүл мэндийн ажилтнуудыг бэлтгэх, хүний нөөцийг төлөвлөх, сургах, урамшуулах ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх

1.2.2.4. Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн, оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг бүрэн нэвтрүүлнэ.

1.2.2.5. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл хяналтыг сайжруулна.

### 1.3. Хүүхэд гэр бүл, хөгжил хамгаалал

Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжил хамгааллын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулан, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрхийн зөрчлийг бууруулж, сэтгэл зүйн эрүүл хүүхдийг төлөвшүүлэн, эх оронч үзэлтэй, иргэний үүрэг хариуцлагаа ухамсарласан, нийгмийн идэвхтэй залуучуудыг бэлтгэнэ

1.3.1. Гэр бүлд ээлтэй, тэгш хүртээмжтэй цогц арга хэмжээг хэрэгжүүлж, түр хамгаалах байрны ая тухтай байдлыг сайжруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1.3.1.1. Гэр бүлийн үнэ цэнэ, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх замаар, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах хөтөлбөрт арга хэмжээг зохион байгуулна.

1.3.1.2. Эрүүл нийгмийг бүтээхэд эрчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний онцлог хэрэгцээ, тулгамдаж буй асуудлыг судлан, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх

1.3.1.3. Гэрч хохирогч түр хамгаалах байрны стандартыг хангах, ажиллах хүчний асуудлыг шийдвэрлэх

**1.3.2. Хүүхдийн болзошгүй эрсдэл, хүчирхийллээс сэргийлэх, хүүхэд хамгааллыг сайжруулна.**

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1.3.2.1. Хамтарсан багийн үйл ажиллагаа шат, шатанд сайжруулна.

1.3.2.2. Хүүхэд, өсвөр үеийнхнийг осол гэмтэлд өртөх, хорт зуршилд автах, урьдчилан сэргийлэх, цахим орчны зохиостой хэрэглээг бий болгох зорилгоор нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулна.

**1.3.3. Залуучуудын хөгжилд дэмжлэг үзүүлэн, олон нийтийн үйл ажиллагаанд оролцоог нэмэгдүүлнэ.**

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1.3.3.1. Залуучуудын мэргэжил боловсрол дээшлүүлэх, мэргэших боломжийг бүрдүүлэн ажиллана.

1.3.3.2. Залуучуудад чиглэсэн олон нийтийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах тал дээр анхаарч, оролцоог нэмэгдүүлэх олон талт арга хэмжээг зохион байгуулна.

1.3.3.3. Залуучуудад гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтыг хөтөлбөр, төслийг дэмжиж, нэмэгдүүлж, хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

1.3.3.4. Төрийн бүх шатны байгууллагын залуу албан хаагчдыг сургах, дадлагажуулах, ур чадварыг дээшлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1.3.3.5. Зорилтот бүлгийн хүүхэд залуучуудад чиглэсэн сайн дурын ажил, санал санаачилгыг бүх талаар дэмжинэ.

#### **1.4. Соёл**

Үндэсний өв соёлоо дээдэлсэн, эх оронч үзэлтэй иргэнийг төлөвшүүлэх, соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн, хотын соёлыг дээдэлсэн иргэнийг төлөвшүүлнэ.

**1.4.1. Бүх нийтэд соёлын боловсрол олгох үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.**

1.4.1.1. Соёлын биет болон биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэн удамшуулах, хамгаалах бодлогыг хэрэгжүүлнэ.

1.4.1.2. Ном унших сонирхлыг нэмэгдүүлэх, бүх шатны номын сангийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

1.4.1.3. Үндэсний өв, соёл, хэл ёс заншилд тулгуурлан иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.

1.4.1.4. Соёл урлагийн салбарын хөгжилд шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

1.4.1.5. Иргэд жуулчдад зориулсан нийтийг хамарсан соёл урлагийн арга хэмжээг зохион байгуулна.

1.4.1.6. Хүүхдийн урлагийн наадмыг жил бүр зохион байгуулна.

#### **1.4.2. Монгол хэл, бичиг**

Монгол хэл, бичгээ иргэн бүр чанартай эзэмшиж хэрэглэж хэвшихэд дэмжлэг үзүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1.4.2.1. Төрийн болон албан хэрэг хөтлөлтийн монгол хэл, монгол бичигт тавигдах шалгуур үзүүлэлтийг өндөрсгөж, төрийн албан хаагчдад монгол бичгийн мэдлэгийг дээшлүүлэх олон талт сургалт нөлөөллийн ажил зохион байгуулна.

1.4.2.2. Нутгийн хэл, соёл, аман аялгууг хадгалах, хамгаалах чиглэлд бүтээлч хөтөлбөрүүд хэрэгжүүлж монгол хэл, бичгийг гадаад, дотоодод түгээн дэлгэрүүлж байгаа байгууллага, багш, суралцагчдыг урамшуулж дэмжинэ.

#### 1.5. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

Чойбалсан хотын онцлогт тохируулан ажлын байр бий болгож, нийгмийн хамгааллын үйлчилгээг зорилтот бүлгүүдэд оновчтой хүргэнэ.

##### 1.5.1 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурлан ажлын байрыг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1.5.1.1. Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээл хамруулах замаар ажлын байрыг нэмэгдүүлэх

1.5.1.2. Хөдөлмөр жуулчлалын үйл ажиллагааг бүхий шатанд дэмжиж хамтран ажиллана.

1.5.1.3. Ажлын байр нэмэгдүүлсэн аж ахуй, нэгж байгууллагын үйл ажиллагааг дэмжих бодлого баримтална.

1.5.1.4. Иргэдийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан ахуй үйлчилгээний салбарыг дэмжин, гэр хорооллын айл өрхүүдэд ахуй үйлчилгээний төв барих ажлыг үе шаттайгаар зохион байгуулах замаар ажлын байрыг нэмэгдүүлж, иргэдийн амьжиргааны тувшнийг дээшлүүлнэ.

1.5.1.5. Сумын онцлогт тохирсон үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлж, орон нутгийн эдийн засгийг төвлөрүүлэн ажлын байрыг нэмэгдүүлнэ.

1.5.1.6. Чойбалсан хотын хэмжээнд худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн байршлыг тогтоон, дэмжиж ажиллана.

##### 1.5.2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн ажлын чиг баримжаа олгох үйлчилгээнд иргэдийг хамруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1.5.2.1. Ажил, мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээг чиг үүргийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

1.5.2.2. Политехник сургуульд суралцагчдын тоог нэмэгдүүлэх, давтан сургах ажлын байраар хангах ажлыг зохион байгуулна.

##### 1.5.3. Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтод бүлгийн өрх иргэнд чиглүүлнэ

1.5.3.1. Олон нийтийн оролцоонд тулгуурлан халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн өрх иргэнд хүргэх ажлыг төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

1.5.3.2. Хууль тогтоомжийн дагуу шаардлага хангасан зорилтот бүлгийн иргэдэд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлнэ.

1.5.3.3. Төр болон төрийн бус байгууллагын түншлэл дээр тулгуурлан ахмад настны өдрийн асрамжийн үйлчилгээг хөгжүүлнэ

1.5.3.4. Ахмад настны насан туршдаа хөгжих боломжийг нэмэгдүүлж, уралдаан тэмцээн зохион байгуулах болон бусад үйл ажиллагаа дэмжин ажиллана.

1.5.3.5. Нийгмийн хариуцлагын хүрээнд хувийн хэвшлийн оролцоотойгоор зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

1.5.4. Хөгжлийн бэрхшээлийн талаар зөв ойлголт зэрэг хандлагыг төлөөвшүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1.5.4.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулж, нөлөөллийн олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.5.4.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тохирсон ажлын байрыг нэмэгдүүлнэ.

1.5.4.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн болон нийгмийн үйлчилгээг авах боломжийг хангаж, аж ахуйн нэгж, байгууллагуудад стандартыг бүрэн хангнуулна.

### 1.6. Биеийн тамир, спорт

Биеийн тамир спортыг хүн амын амьдралын хэв маяг, амьдралын чанарыг дээшлүүлэх хэрэглүүр болгож, идэхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх, орчин нөхцөлийг сайжруулан, бүх түвшинд тамирчдын ур чадварыг нэмэгдүүлнэ.

1.6.1. Хүн амыг идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэж, эруул мэндээ дэмжихэд чиглэсэн олон талт орчин нөхцөл, боломжоор хангаж, нийтийн биеийн тамирын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, бие бялдрын хөгжил, боловсролыг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1.6.1.1. Иргэдийг эрүүл чийрэг байх зан үйлийг эрхэмлэсэн, өдөр тутмын дасгал хөдөлгөөн, зөв хооллолт, эрүүл амьдралын хэв маяг бүхий дадалд сургаж, тогтмолжуулах, энэ чиглэлээр шинэ санаачилга гаргасан иргэн, аж ахуй дэмжин хамтран ажиллана.

1.6.1.2. Биеийн тамирын орон тооны арга зүйчийн тоог нэмэгдүүлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, хамрах хүрээг нэмэгдүүлнэ.

1.6.1.3. Хүүхэд залуучуудын дунд олон төрөлт тэмцээн уралдаан зохион байгуулах, бие бялдрыг хөгжүүлэх олон талт арга хэмжээг зохион байгуулна.

1.6.1.4. Өвлийн улиралд зохион байгуулах биеийн тамир, спортын арга хэмжээг өргөжүүлнэ.

1.6.1.5. Иргэдийн хэрэгцээнд нийцсэн биеийн тамирын үйл ажиллагааг өргөжүүлж, нийтийг хамарсан томоохон уралдаан тэмцээнүүдийг уламжлал болгон зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. /Чойбалсан хотын нэрэмжит хотын аварга шалгаруулах тэмцээн/

1.6.1.6. Үндэсний өв соёлыг түгээх, үндэсний спортоор хичээллэх, өв тээгч, хүүхэд залуучуудыг дэмжих, сурталчлан таниулах, олон талт арга хэмжээг зохион байгуулна.

## **ХОЁР . ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

### 2.1. Төсөв санхүү

Төсөв санхүүгийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан, орон нутгийн өмчит аж ахуй нэгжүүдийн үр өгөөжийг нэмэгдүүлж, төрийн бүх шатанд сахилга хариуцлагыг сайжруулна.

2.1.1. Орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж, үр ашиггүй зардлыг бууруулах замаар хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.1.1.1. Иргэн, аж ахуй нэгжийн татварын хууль тогтоомжийн мэдлэгийг сайжруулна.

2.1.1.2. Төрийн болон орон өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, тэдгээрийн бүртгэл мэдээлэл, үнэлгээ, тайланг ил тод, нээлттэй болгон, өмч эзэмшигчдийн хариуцлагыг дээшлүүлнэ.

2.1.1.3. Төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмыг баримталж, үйлдвэр худалдаа, үйлчилгээний салбарын бизнесийн таатай орчныг бурдуулж, төр, хувийн хэвшилийн хамтын ажиллагааг дэмжинэ.

2.1.1.4. Татварын тайлагнант, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд саадгүй хүргэх, татварын суурийг нэмэгдүүлнэ.

2.1.1.5. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэвтрүүлэхийн тулд орон нутгийн онцлогт тохирсон төсөл, хөтөлбөрийг дэмжиж хөрөнгө оруулагчдад шаардлагатай мэдээлэл, дэмжлэг үзүүлэх, хууль эрх зүйн тогтвортой байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлнэ.

2.1.1.6. Орон нутгийн орлогыг нэмэгдүүлж, зарцуулалтын үр дүнг сайжруулна.

2.1.1.7 Уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж, ахуй нэгжүүдээс нийгмийн хариуцлагын хүрээнд ОНХС-д оруулах төсвийг нэмэгдүүлэх.

**2.1.2. Улсын орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, чанарыг сайжруулна.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.1.2.1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтыг хууль журмын дагуу хэрэгжүүлэх, санал авах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

2.1.2.2. Өмнөх гэрээний үүргээ бүрэн биелүүлээгүй аж ахуйн нэгжийг тендерт оролцсон тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болгох зарчмыг баримтлан хариуцлагыг сайжруулна.

**2.1.3. Төрийн худалдан авах ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлэх замаар хүний оролцоог бууруулж, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлнэ.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.1.3.1. Төрийн худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу хэрэгжүүлэн ажиллана.

2.1.3.2. Төрийн худалдан авах ажиллагааны мэдээллийг цахим системээр дамжуулан олон нийтэд хүргэх хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.1.3.3. Бүх шатны худалдан авах ажиллагаанд болон түүний гүйцэтгэлийн явцад хяналт, шалгалтыг тогтмол явуулж, иргэд, олон нийтийг мэдээллээр хангана.

## **2.2 Хүнс, хөдөө, аж, ахуй**

**2.2.1. Малчны хоршоог чадавхжуулна.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.2.1.1. "Шинэ хоршоо-хөдөлгөөн"-ийг сумын хэмжээнд өргөтгөн, малчдын хоршоодод хөнгөлөлттэй зээл олгох, малын гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэх тогтолцоог сайжруулна.

2.2.1.2. Мал аж ахуй чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хоршоодыг бодлогоор дэмжиж, хоршооны захирагааны сургалтыг зохион байгуулна.

2.2.1.3. Хөрш зэргэлдээ найрамдалт харилцаатай улс орнуудаас эрчимжсэн мал аж ахуйн туршлага судлах ажлыг зохион байгуулж, малчдыг оролцуулна.

2.2.1.4. Малчин өрхүүдийн нийгмийн асуудалд тулгарч буй хүндрэлийг шийдвэрлэх, зөвлөгөө мэдээлэл хүргэх ажлын хэсэг байгуулж айл өрхүүдээр очиж мэдээллээр хангаж ажиллана. Малчдад зориулсан төсөл, хөтөлбөрийн талаарх нэгдсэн өдөрлөг зохион байгуулах, малчдад үүлдэр угсаа сайжруулах зөвлөгөө үзүүлнэ.

**2.2.2. Мал эмнэлгийн оношилгоо, шинжилгээний түвшинг нэмэгдүүлж, мал, амьтны гоц халдварт, халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, халдварт бус өвчлөлийг бууруулна.**

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.2.2.1. Орон нутгийн төсвийн зардлаар хийдэг дотрын халдварт хордлого, цусан халдварт, дуут хавдар, гахайн цусан халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг аймаг, орон нутгийн хэмжээнд зохион байгуулна.

2.2.2.2. Мал эмнэлгийн ажилтны боловсрол мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулна.

2.2.2.3. Малын эрүүл бүсийг байгуулан шаардлагатай дэд бүтцийг шийдвэрлэх тал дээр бодлогоор дэмжиж ажиллана.

2.2.2.4. Малын гоц халдварт болон халдварт, шимэгчтэх өвчинөөс урьдчилан сэргийлэх ажлыг холбогдох хуль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллана.

**2.2.3. Хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуй нэгжийг дэмжин ажиллана.**

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.2.3.1. Газар тариалангийн эргэлтийн талбайн хэмжээг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулах, тариалангийн үр, хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгийг ханггуулна.

2.2.3.2. Дотоодын хэрэгцээг хангахуйц услалтын талбайн хэмжээг нэмэгдүүлж, нарийн ногооны дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

2.2.3.3. Зоорины хангамжийг нэмэгдүүлэх, шинээр зоорь барьж байгаа аж ахуйн нэгжийг хөнгөлөлттэй зээлээр хангахад анхаарна.

2.2.3.4. Жимс, жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.2.3.5. Мал мах, түүхий эд боловсруулах үйлдвэрийг бий болгож малчдын бодит орлогыг нэмэгдүүлнэ

2.2.3.6. Байгалийн хадлан бэлтгэгчид, тэжээлийн ургамал тариаланчдыг бодлогоор дэмжиж ажиллана.

2.2.3.7. Орон нутгийн хөрс, цаг агаарын онцлогийг судлан тариалах боломжтой жимс, жимсгэнэ тариалалтыг нэмэгдүүлнэ.

2.2.3.8. Өрхийн тариалангийн үйлдвэрлэл эрхэлж буй иргэдийн бүртгэл, мэдээллийг сайжруулан сайн туршлагыг алдаршуулан, олон талт арга хэмжээ зохион байгуулна.

**2.2.4. Хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийн хуртээмжийг нэмэгдүүлэх:**

2.2.4.1. Хөдөө аж ахуйн техникийн тоог нэмэгдүүлэх санхүүгийн дэмжлэг, техникийн тусламжийн хүртээмжийг сайжруулах бодлого хэрэгжүүлнэ.

### 2.3 Үйлдвэр, худалдаа

Үйлдвэр, үйлчилгээний салбарыг хөгжүүлэх бодлогыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж, дотоодын үйлдвэрлэл болон экспортыг нэмэгдүүлнэ.

#### 2.3.1. Дотоодын нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэр, үйлчилгээний салбарын эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.3.1.1. Чойбалсан хотод барилгын материалын үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагыг бодлогоор дэмжиж ажиллана.

2.3.1.2. Бүсийн үйлдвэр технологийн парк байгуулж, орон нутгийн итгэмжлэгдсэн лабораторийн үйл ажиллагааг чадавхжуулж, итгэмжлэлийн хүрээг нэмэгдүүлнэ.

2.3.1.3. Дайвар бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэр, цех байгуулахад дэмжлэг үзүүлж, бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар, гадаадын зах зээлд нийлүүлэх ажлыг бодлогоор дэмжинэ.

2.3.1.4. Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагыг төрийн худалдан авалтад хамруулах замаар махны үйлдвэрлэл, мал борлуулах сүлжээний үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

2.3.1.5. Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олгох журмын үйл ажиллагааны чиглэл, хэмжээг орон нутгийн онцлогт тохирсон байдлаар шинэчилнэ.

2.3.1.6. Орон нутагт хэрэгжиж буй томоохон төсөл, хөтөлбөр, үйлдвэрийн ханган нийлүүлэлтэд жижиг дунд бизнес эрхлэгчдийг холбох ажлыг зохион байгуулна.

2.3.1.7. Орон нутагт хөгжүүлэх нэн шаардлагатай бизнесийн салбарын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.

2.3.1.8. Үйлчилгээний байгууллагуудын чанар, стандартыг сайжруулах чиглэлээр сургалт зохион байгуулж, оролцогчдын дунд урамшуулалт уралдаан зарлана.

2.3.1.9 Гадна талбайн худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг стандартын шаардлага хангасан орчныг бүрдүүлэх, байршлыг тогтоох ажлыг зохион байгуулна.

2.3.1.10. Үндэсний томоохон үйлдвэрлэгчдийн салбарыг Чойбалсан хотод байгуулах саналыг тавьж, урих, бодлогоор дэмжин ажиллана

### 2.4. Гадаад харилцаа, аялал жуулчлал

Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, байгаль орчны тогтвортой байдлыг хадгалах хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

#### 2.4.1. Гадаад харилцаа

2.4.1.1. Хөрш зэргэлдээ болон гуравдагч орны хотуудтай хамтын ажиллагааны баримт бичгийн хүрээнд нийгэм, эдийн засгийн бүхий үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

2.4.1.2. Төр, хувийн хэвшлийн үйл ажиллагааг сайжруулах, сайн туршлыг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд хөрш зэргэлдээ болон гуравдагч орнуудад туршлага солилцох, урт болон богино хугацааны сургалт, зөвлөгөөнд оролцоход дэмжлэг үзүүлнэ.

2.4.1.3. Олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлж, орон нутагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

2.4.1.4. Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсэд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татаж төр хувийн хэвшлийн түншлэлийг дэмжинэ.

2.4.2 Байгаль, түүх, соёлын өөд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.4.2.1. Бизнесийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг бодлогоор дэмжих ажиллана.

2.4.2.2. Монголын үндэсний онцлогтой аялал жуулчлалын төвүүдийг байгуулж, гадаад дотоодын жуулчдын шинэ урсгалыг бий болгох, тоог нэмэгдүүлэх зорилгоор олон улсын чанарт нийцсэн үйлчилгээг хөгжүүлнэ.

2.4.2.3. Хэрлэн голын эрэг дагуу Хэрлэн орчмын аялал жуулчлалыг бодлогоор хэрэгжүүлнэ.

2.4.2.4. Гадаадын болон дотоодын аялагчдыг татах, "Найрсаг Чойбалсан", "Морь", "Талын малчин айл" зэрэг аяллуудыг боловсруулж брэнд аялал болгон хэрэгжүүлнэ.

2.4.2.5. Хот доторх түүхэн аялал жуулчлалын маршрутыг бий болгож, хотоороо бахархах, хайрлан хамгаалах үзлийг иргэн бүрд төлөвшүүлэх, гаднаас ирэх жуулчдын заавал үзэх хотын брэнд газрыг бий болгоно.

2.4.2.6. "Хотын соёл- мэндчилгээ инээмсэглэлээс эхэлнэ" нөлөөллийн сургалт үйл ажиллагааг бүх хүн амд зохион байгуулна.

2.4.2.7. Жуулчдыг мэдээллээр хангах олон талт арга хэмжээг зохион байгуулна.

2.4.2.8. Шинэ аяллын бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх иргэн, аж ахуй нэгжтэй хамтран ажиллана.

2.4.2.9. Чойбалсан хотод үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад тавигдах ерөнхий шаардлагыг хангулан ажиллана.

2.4.2.10. Хот орчмын аялал жуулчлалыг хөгжүүлнэ. Дотоодын амралт, сувилал, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг дэмжинэ.

2.4.2.11 Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч иргэн аж, ахуй нэгжтэй хамруулсан олон улсын зөвлөгөөн зохион байгуулна.

## ГУРАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

### 3.1. Барилга, хот байгуулалт

Сумын хэмжээнд газар зохион байгуулалтын төлөвлөлтийн дагуу дэд бүтцийг нэмэгдүүлэх, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.

3.1.1. Инженерийн шугам сүлжээг сайжруулах иргэдийн орон нутагт ажиллах, амьдрах ая тухтай орчин бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1.1.1. Цэвэрлэх байгууламжийн хэвийн үйл ажиллагааг хангана.

3.1.1.2. Чойбалсан хотын гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох, өргөтгөх ажлыг үе шаттай хэрэгжүүлж иргэдийн ая тухтай шинэ амьдралын хэв маягийг бий болгоно.

3.1.1.3. Амины орон сууцны хотхон, хороолол барьж байгуулах Засгийн газрын хөтөлбөрийг дэмжин хэрэгжүүлнэ.

3.1.1.4. Гэр хорооллыг орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.1.1.5 Чойбалсан хотын арын 4 эгнээ замд явган зорчигчийн хөдөлгөөн ихтэй газруудад нүхэн гарц байгуулах ажлыг эхлүүлэх.

3.1.1.6. Алслагдсан багуудын дэд бүтцийг сайжруулан уст цэг, цахилгаан хангамж, нийтийн тээврийн асуудлыг шийдвэрлэж төвлөрлийг бууруулна.

3.1.1.7.Хотын төв хэсэгт Хэрлэн голын шинэ төмөр бетон гүүр барьж байгуулах байршлыг тодорхой болгож зураг төсөв гаргуулж улсын төсвөөр хийх ажлын жагсаалтад оруулах

3.1.1.8. Чойбалсан хотод стандартад нийцсэн нийтийн ариун цэврийн байгууламжуудыг байгуулна.

3.1.1.9. Сумын хэмжээнд галын болон түргэн тусlamжийн машин нэвтрэх боломжгүй болсон эгнээ гудамжны судалгааг нарийвчлан гаргаж, дараагийн шатанд хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг төлөвлөн зохион байгуулна.

3.1.1.10. Хэрлэн гол дагуу усан хангамжийн эх үүсвэрүүдийг үерээс хамгаалах зорилгоор усны тохируулгын усан сан, далан байгуулах ажлыг эхлүүлнэ.

3.1.2. Чойбалсан хотын дулаан хангамжийн нэгдсэн эх үүсвэрийг бий болгож, агаарын бохирдлыг бууруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1.2.1 Шинээр төлөвлөгдсөн орон сууцны хэсгүүдийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн дэд бүтцийн зураг төслийг гүйцэтгүүлж, ажлыг эхлүүлнэ.

3.1.3. Ерөнхий төлөвлөлтийн дагуу дэд бүтцийг хөгжүүлж, орон нутагт ажиллаж, амьдрах тав тухтай орчин бий болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1.3.1. Сумын төв доторх хатуу хучилттай авто зам, явган болон унадаг дугуйн зам, гэрэлтүүлгийг өргөтгэн, шинээр ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, засвар арчлалт, тэмдэг, тэмдэглэгээг стандартад нийцүүлэн хийнэ.

Чойбалсан хотын төв доторх явган болон унадаг дугуйн зам, зогсоол байгуулах, гэрэлтүүлгийг өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, тэмдэг, тэмдэглэгээг стандартад нийцүүлнэ.

3.1.3.2. Хэрлэн гол дагуу усан хангамжийн эх үүсвэрүүдийг үерээс хамгаалах зорилгоор усны тохируулгын усан сан, далан байгуулах ажлыг эхлүүлэх.

3.1.3.3. Чойбалсан хотын гэр хорооллын захын хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг шинээр төлөвлөж хүчдэлийн уналтыг арилгах ачааллын зохицуулалт хийж, чадлын алдагдал багатай трансформатораар тоноглоно.

3.1.3.4. Чойбалсан хотын цахилгаан шугам сүлжээг 35кВ-ын гадна цагариг схемээр тэжээж хотын захаар үйлдвэрлэл хөгжих боломжтой цахилгаан хангамжийн найдвартай алдагдалгүй систем үүсгэнэ.

3.1.3.5. Багуудад хэсэгчилсэн дахин төлөвлөлтийг Чойбалсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан шат дараатай хийнэ.

3.1.3.6. Орон нутгийн чанартай авто зам, гүрүүдэд засвар арчлалтыг жил бүр хийнэ.

3.1.3.7 Сэргээгдэх эрчим хүчийг үйлдвэрлэх, ашиглах чиглэлээр бодлогыг дэмжиж ажиллана.

### 3.1.4 Тохижилт бүтээн байгуулалтын ажил

3.1.4.1. Гэр хорооллын шороон болон сайжруулсан хайрган хучилттай замуудыг бүрэн гэрэлтүүлэг, явган хүний замыг сайжруулах

3.1.4.2. Засмал зам, гэрэлтүүлэг, явган хүний зам, дугуйн зам, ногоон орчин бүхий “Цогц гудамж” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.1.4.3. Хотхон, байруудын дундах хүүхдийн тоглоомын талбайг шинэчлэн, хүүхдийг эрүүл чийрэг зөв хөгжүүлэх үүрэг бүхий тоглоом, элс, ус, ногоон байгууламжийг бүрдүүлж, бүх насны хүмүүсийн амрах орчныг бүрдүүлэхийн төлөө ажиллана.

3.1.4.4. Хуучны байруудын өнгө үзэмжийг сайжруулж, гадна фасадыг үе шаттай хийнэ.

3.1.4.5. Хотын өнгө зүс, соёлд таагүй нөлөөтэй, олон жил ашиглахгүй удсан, муудсан барилга байгууламжийг эдийн засгийн эргэлтэд оруулж, өнгөлөг орчин бүрдүүлэхэд анхаарч ажиллана.

3.1.4.6. Хэрлэн сумын зарим гудамжийг явган хүнд зориулсан худалдаа, үйлчилгээний “авто машингүй гудамж” болгоно.

3.1.4.7. Захын хэд хэдэн багуудад, иж бүрэн цогцолбор тоглоомын талбай байгуулна.

3.1.4.8. Орон нутгийн чанартай гүүрний засвар, арчлалтыг сайжруулах

3.1.4.9.Өсвөр насны хүүхдийн онцлогт тохирсон шинэлэг спорт талбайг байгуулах

### 3.1.5 Газрын харилцаа

Сумын хэмжээнд газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийж, газар олголтыг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1.5.1. Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулна.

3.1.5.2. Хот, тосгон бусад суурин газарт газрын төлөв, байдал чанарын улсын хянан баталгаа хийлгүүлнэ.

3.1.5.3. Иргэн бүрийг өмчлөлийн газартай болгох ажлыг эрчимжүүлж, шинээр өмчлүүлж буй газрын төлөвлөлт, дэд бүтцийг шийдэх, хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт суулган шийдвэрлүүлнэ.

3.1.5.4. Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг [www.mle.mn](http://www.mle.mn) сайтаар болон танхимаар ил тод нээлттэй зохион байгуулж, иргэд олон нийтийн оролцоог хангаж ажиллана.

3.1.5.5. Чойбалсан хотын хаягжуулалтын ажлыг стандартын дагуу хэрэгжүүлж, эгнээ гудамжны эмх цэгцийг сайжруулах ажлыг зохион байгуулна.

3.1.5.6 Газар зохион байгуулалттай холбоотой холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах /Шаардлагатай газрыг цуцлах шийдвэр гаргах, хэрэгжилтийг хангах/

### 3.1.6 Орон сууц, нийтийн аж ахуй

3.1.6.1. Гэр хорооллын дахин төлөвлөн барилгажуулах, газрыг дахин зохион байгуулах төслийг үргэлжлүүлэн, инженерийн болон нийгмийн дэд бүтцээр хангах ажлыг эрчимжүүлнэ.

3.1.6.1.1. Төвийн гэр хорооллыг дахин төлөвлөлтэд оруулна.

3.1.6.1.2. Гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулна.

3.1.6.1.3. Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагаа, стандартыг сайжруулна.

3.1.6.1.4. Хуучны орон сууцуудын инженерийн шугам сүлжээг сайжруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

## ДӨРӨВ. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

4.1. Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангаж, орон нутагт хуулийн хэрэгжилтийг хангуулж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

4.1.1. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

4.1.1.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, хохирогч хамгаалах байрны стандартын шаардлагыг хангуулна.

4.1.1.2. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн “Олон нийтийн цагдаа”-г ажиллуулах тал дээр хамтран ажиллана.

4.1.1.3. Хүүхдийг гэмт хэрэг зөрчилд орж буй шалгаан нөхцөлийг судлан хариу арга хэмжээг авч ажиллана.

4.1.1.4. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, холбогдох дэмжлэгийг үзүүлнэ.

4.1.1.5. Нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрх зүйн сургалтыг иргэд, олон нийтэд болон төрийн албан хаагчдад зохион байгуулна.

4.1.1.6. Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гишүүдийн оролцоог идэвхжүүлнэ.

4.1.1.7. Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна.

4.1.1.8. Хууль зүйн тусалцааны төвийг бий болгон иргэдийн эрх зүй, хүний эрхийн мэдлэгийг дээшлүүлнэ.

4.1.1.9. Бүх төрийн цахим гэмт хэрэг, мөрийтэй тоглоомтой тэмцэх ажлыг эрчимжүүлнэ.

4.2. Иргэдэд төрийн үйлчилгээг хүртээмжтэй, нээлттэй, чирэгдэлгүй хүргэдэг шуурхай төрийн албыг бий болгоно.

4.2.1. Бүх шатны төрийн байгууллага, төрийн албан хаагчдын чадавхыг бэхжүүлж, төрийн байгууллын шийдвэр гаргах ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, төрийн үйлчилгээний цахим шилжилтийг үр дүнтэй зохион байгуулж, үйлчилгээ авч буй иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлнэ.

4.2.1.1. Төрийн албан хаагчдын мэдлэг үр чадварыг хөгжүүлж, сахилга хариуцлагыг өндөржүүлэн, иргэд олон нийтэд төрийн үйлчилгээг ил тод нээлттэй хүргэнэ.

4.2.1.2. Иргэд төрийн үйлчилгээг нэг цэгээс цаг хугацаа алдалгүй шуурхай авах боломжийг бүрдүүлж, төрийн үйлчилгээний операторын үйлчилгээ /E-MONGOLIA.MN/-ыг өргөжүүлнэ.

4.1.1.3. Төрийн байгууллагуудын зарим үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, төрийн үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангана.

4.3. Орон нутгийн хүний нөөцийн бодлого

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

**4.3.1. Хүний нөөцийн бодлогыг чадахуйн зарчимд нийцүүлнэ.**

4.3.1.1. Төрийн байгууллагуудыг боловсон хүчинээр хангах хэрэгцээг тодорхойлох судалгаа хийж, шаардлагатай мэргэжлээр суралцаж буй оюутнуудад суралцах үеийн тэтгэлэг, зээл олгох тогтолцоог бүрдүүлнэ.

4.3.1.2. Төрийн үйлчилгээнд байгууллагын гүйцэтгэх албан тушаалын сүл орон тоог олон нийтэд мэдээлж, нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.

4.3.1.3. Төрийн албаны ерөнхий шалгалтын явц, үйл ажиллагааг олон нийтийн хяналт, оролцоотой болгон, ил тод байдлыг хангах тал дээр хамтарч ажиллана.

**4.3.2. Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангаж, мэргэшил дээшлүүлэх.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

4.3.2.1. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

4.3.2.2. Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор сургалтын хөтөлбөрийг сайжруулж, орон нутгийн хэрэгцээнд зориулсан сургалт зохион байгуулна.

4.3.2.3. Ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түшинг үнэлж, тогтмол дүгнэлт гаргах замаар төрийн албан хаагчдын гүйцэтгэлийг сайжруулна.

4.3.2.4. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, амьдралын түшинг дээшлүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

**4.3.3. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийг бууруулна.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

4.3.3.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг мөрдөж, зөрчил гарсан тохиолдолд зохих арга хэмжээ авч ажиллана.

4.3.3.2. Төрийн байгууллагын ёс зүйн дэд хороог чадавхжуулах, гишүүдэд ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгуулна.

4.3.3.3. Ёс зүйн хэм хэмжээг сахих, ажлын гүйцэтгэлийг тогтмол хянаж, тайлagnана.

**4.4 Төр иргэний хамтын ажиллагаа**

**4.4.1 Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах**

4.4.1.1. Бүх шатны төрийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд ил тод нээлттэй, эргэх холбоотой, иргэн төвтэй байлгана.

4.4.1.2. Төрийн бодлого шийдвэрт иргэдийн саналыг тусах, таар иргэний хамтын ажиллагаанд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх тал дээр бүх шатны нутгийн өөрөө удирдах байгууллага буюу ИТХуралтай хамtran ажиллана.

4.4.1.3. Иргэдтэй уулзах өдөрлөг, нээлттэй хаалганы өдөрлөгийг тодорхой давтамжтайгаар зохион байгуулна.

**4.5. Орон нутгийн хамгаалалт**

Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн бэлэн байдал хангах, дайчилгааны төлөвлөгөөг боловсронгуй болгох, иргэдийн эх орноо хамгаалах, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх бэлтгэл ажлыг дээшлүүлэх, хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлнэ.

**4.5.1. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэх, дайчилгааны төлөвлөгөөг шинэчилж, хүүхэд залуучуудын эх оронч үзлийг нэмэгдүүлнэ.**

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.5.1.1. Дайчилгааны төлөвлөгөөг шинэчилж, дайчилгааны болон орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бэлэн байдлыг хангаж, хүүхэд залуучуудын эх оронч үзлийг төлөвшүүлэх арга хэмжээг тогтмолжуулна.

4.5.1.2. Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд, иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх замаар батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллана.

**4.5.2. Гамшигаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлнэ**

Байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, болзошгүй гарз хохирлын эрсдэлийг бууруулах, даван туулах чадавхыг бэхжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.5.2.1. Сумын Онцгой комисс, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний гамшигаас хамгаалах чадавхыг сайжруулах, бэлтгэл бэлэн байдлыг хангах, сургалт, мэдээллийн арга хэмжээг зохион байгуулна.

4.5.2.2. Гамшигаас урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагаанд шаардлагатай техник, багаж хэрэгслийг нэмэгдүүлнэ.

**ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ**

**5.1. Байгаль орчин**

**5.1.1. Байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх замаар тэнцвэрт байдлыг хадгална.**

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.1.1.1. Гадаргын ус хуримтлуулах хэв цөөрөм байгуулах, усан сан бүхий газар нөхөн сэргээх төсөл, арга хэмжээг дэмжиж ажиллана.

5.1.1.2. Төв суурин газрын ундны усны нөөцийн судалгааг хийлгэж, усны чанар, аюулгүй байдлыг хангана.

5.1.1.3. Усны хэрэглээ, ашиглалтын хэмнэлтийг бий болгож, дахин ашиглахыг дэмжинэ.

5.1.1.4. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд эрчимжүүлж, төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

5.1.1.5. Хар ялаа, ойн хөнөөлт шавжтай тэмцэх, ойг түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулах, ойжуулалт, ойн зурvas байгуулах ажлыг зохион байгуулна.

5.1.1.6. Олон улсын төсөл хөтөлбөртэй хамтран мод бут тарих, мод үржүүлгийн газрыг чадваржуулах болон иргэд олон нийт, өсвөр үеийнхэнд экологийн боловсрол олгоно.

**5.1.2. Байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, ногоон үзэл санаа, дадлыг нэвтрүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулж хувь нэмэр оруулна.**

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.1.2.1. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох арга хэмжээнүүдийг төлөвлөж, хэрэгжүүлэх тал дээр хамтран ажиллана.

5.1.2.2. Дэд бүтцийн хөгжилд дэвшилтэт техник технологи нэвтрүүлж, агаар, орчны бохирдлыг бууруулах тал дээр хамтарч ажиллана.

5.1.2.3. Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицийн үйл ажиллагааг тогтвортой болгон хуурайшилтын эрсдэлийг бууруулна.

5.1.2.4. Энгийн болон аюултай хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах оновчтой менежментийн тогтолцоог бүрдүүлнэ.

## 5.2. Ногоон байгууламж бүхий хот болох

5.2.1. Чойбалсан хотын ногоон байгууламжийг сайжруулах, цэцэрлэгжүүлэх, ойжуулах, иргэдийг ая тухтай амьдрах нөхцөлийг нэмэгдүүлэх ажлыг зохистой төлөвлөн хэрэгжилтийг хангах тэл дээр төр, иргэн, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сайжруулна.

5.2.1.1. Хот суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан цэцэрлэгт хүрээлэнгийн тоог нэмэгдүүлнэ.

5.2.1.2. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн ногоон байгууламж цэцэрлэгжүүлэлтийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх, арчлалт хамгаалалтыг сайжруулна.

5.2.1.3. Гэр хорооллын айл өрх хашаандаа мод тарих, ногоон байгууламж барих санал санаачилгыг дэмжинэ.

5.2.1.4. Шарилжгүй хот аяныг хэрэгжүүлнэ.

## 5.2.2 Хотын тоосжилтыг бууруулах, иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлэх

5.2.2.1. Стандартад нийцсэн спорт, хүүхдийн тоглоомын талбайг нэмэгдүүлнэ.

5.2.2.2. Байгууллагуудын гаднах зам талбайг тохижуулна.

5.2.2.3. Сул шороон хөрсийг зүлэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хатуу хучилттай болгох, зөөвөрлөх, тэгшлэх ажлыг үе шаттай зохион байгуулж тоосжилтыг бууруулна.

5.2.2.4. Голын эрэг дагуу олон нийтийн соёл амралтад зориулсан, тохилог орчныг бүрдүүлнэ.

## 5.2.3 Агаарын бохирдлыг бууруулж, байгальд ээлтэй, үр ашигтай хэрэглээг нэмэгдүүлэх замаар эрүүл аюулгүй орчныг бүрдүүлнэ.

5.2.3.1. Сайжруулсан түлшний хэрэглээг нэвтрүүлнэ.

5.2.3.2. Агаарын чанарын хяналт судалгааг холбогдох байгууллагаар хийлгэнэ.

5.2.3.3. Авто тээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулагч бодисын хэмжээг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ.

5.2.3.4. Агаарын бохирдол бууруулахад иргэд олон нийтийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, эрүүл амьдрах зөв дадлыг төлөвшүүлнэ.

## 5.3. Хөрс, орчны бохирдлыг бууруулах

### 5.3.1. Бохирдсон хөрсийг нөхөн сэргээх

5.3.1.1. Нүхэн жорлонгоос үүдэлтэй хөрсний бохирдлыг бууруулах, бүх нийтээр дагаж мөрдөх уриалга гаргаж ажиллана.

5.3.1.2. Хөрсний бохирдол бууруулах хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлнэ.

5.3.1.3. Гэр хорооллын айл өрхүүдийн шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжид шилжүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

#### 5.4. Хог хаягдлын менежментийг сайжруулан, Цэмцэр хот болох

##### 5.4.1. Хог хаягдлыг бууруулах чиг үүргийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах

5.4.1.1. “Хэрлэн тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын дүрэм шинээр боловсруулан батлуулах

5.4.1.2. “Хэрлэн тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын бүтэц орон тог өөрчилж, удирдлага зохион байгуулалтыг сайжруулна.

5.4.1.3. Хог хаягдлыг зайлцуулах, тээвэрлэх үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай тоног төхөөрөмжийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

5.4.1.4. Хог хаягдлын хураамжийг бүрэн төвлөрүүлж, зарцуулалтын хяналтыг сайжруулж, ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллана.

5.4.1.5. Нэгдсэн хогийн цэгийн стандартыг хангуулах, холбогдох төлөвлөлтийг хийлгэнэ.

5.4.1.6. Нийтийн эзэмшлийн талбай, орц, гэр хороолол орчим дах хогийн савны тоог нэмэгдүүлнэ.

5.4.1.7. Хог хаягдлын менежментийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулж, сайн туршлага нэвтрүүлж, нутагшуулах

##### 5.4.2 Хог хаягдлыг бууруулах тал дээр Төр, иргэн, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах

5.4.2.1. Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр гарган хэрэгжилтийг хангаж, иргэд олон нийтэд мэдээлэн ажиллана.

5.4.2.2. Бүх нийтийн цэвэрлэгээг тогтмол зохион байгуулж, хэвшүүлнэ.

5.4.2.3. Иргэд олон нийтийн үүргийг ухамсарлуулах, олон талт нөлөөллийн ажлыг зохион байгуулна.

5.4.2.4. Бүх шатны төрийн байгууллага, албан хаагчдыг хог цэвэрлэгээтэй холбоотой олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулна.

5.4.2.5. Холбогдох хууль тогтоомжийн дагуу урамшуулах асуудлыг шийдвэрлэнэ.

5.4.2.6. Дээрх ажил арга хэмжээтэй холбоотойгоор хариуцлагын арга хэмжээг бүх шатанд тооцож ажиллана.

#### 5.5.Иргэнд ээлтэй орчныг бүрдүүлэх

##### 5.5.1. Иргэдийг эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх

5.5.1.1. Золбин нохой, муур устгалыг жил бүр чанартай зохион байгуулна.

5.5.1.2. Зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг холбогдох журмын дагуу зайлцуулах, устгах, булшлах ажлыг зохион байгуулна.

5.5.1.3. Үндны усны худгуудын эрүүл ахуйн стандартын шаардлагыг бүрэн хангах тал дээр мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах

5.5.1.4. Гэр хорооллын гудамж талбайг үе шаттайгаар камержуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.

5.5.1.5. Ариутгал халдвартгүйжүүлэлтийн ажлыг мэргэжлийн чиг үүргийн байгууллагатай хамтран чанартай зохион байгуулна.

5.5.1.6. Бунхан толгой орчмыг дөрвөн улирлын турш иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх цогцолбор төв болгоно.